

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



УЛС ТӨР

ЭНЭ ЖИЛЭЭС ЗУНЫ ЦАГИЙН ТООЛОЛД ШИЛЖИХГҮЙ ГЭВ

ДЭЛХИЙ

В.ПУТИНЫ БАС НЭГ "ДАЙСАН" УХЛИЙН ИРМЭГТ БАЙНА

II нүүрт

IV нүүрт

Дугаарын 60 мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Зөв хэвшил тогтооё

Э.ТУУЛ

ЭХЛЭЭД ГИШҮҮДЭЭ БУЦААЖ ТАТДАГ БОЛГОЧИХ...



Н.ПУНЦАГБОЛД

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны онгорсон мянгар

гарагийн хуралдаанаар Эрүүгийн хуульд нэмэлт, оорчолт оруулах тухай

мөрдөх журмын тухай хуульд

нэмэлт, оорчолт оруулах тухай хуулийн төслийдний анхны

хэлэлцүүлгийг хийсн. Энэ хуулийн төслийтэй холбоотойгоор

гишүүдяан бүрийнласуултасууж,

хариулт авсан. Харин тэр дунд зарим нэг гишүүн сэтгүүлчдэд

эрүүгийн хариуцлага хулээлгэж

боловгүй юу гэж асуугаад, ногөө

“Боломжтой” гээд харнулаад сууж байна.

Үргэлжлэл нь III нүүрт

MINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын
мэдээ мэдээлэл таны гар...

TATAK PLAY STORE

TATAK APP STORE

ЧУХАЛ СЭДЭВ

Ч.ГАНТУЛГА: Эхний ээлжинд зогсонги байдалд орчихсон барилгын салбараа хөдөлгөж, эргэлтэд оруулах хэрэгтэй байна

Н.ПУНЦАГБОЛД

НИХХ-ын төлөөлөгч, БНУУ-ын өргөмжит консул, ИХ-ын Санхүү, эдийн засаг, Хууль зүй, төрийн байгуулалтын хорооны гишүүн, Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны дэд хорооны дарга Ч.Гантулгыг “Чухал сэдэв” буландаа урьж, ярилцаа.

-Улаанбаатар хотод хамгийн их тулгамдаж байгаа асуудлын нэг бол утаа. Утгаа гамшигийн хэмжээнд хүрчилээ гэдгийг дарга нар хүлээн зөвшөөрөөд, тодорхой арга хэмжээндийг авч эхлээд байна.

Хотын дарга тодорхой захирамж гаргасан. Иргэдийн хурлаар хэлэлцээ, тодорхой ажлуудыг хийж байгаа байх. Чухам ямар чиглэлийг барьж ажиллаж байна вэ?

-НИХХ-ын долдугаар чуулган нэгдүгээр сарын 28-нд хуралдан. Энэхүү чуулгандын үндсэн хэлэлцэх асуудал нь гамшигийн хэмжээнд хүрээд байгаа утааны асуудал байсан. Гэнэт л иөнөөдөр утаатай болоод чуулганаар хэлэлцэх байгаа асуудал биш юм. Сүүлийн 8-10 жилийн хугацаанд хуримтлагдаж ирсэн нийгэмд тулгарч буй бидний шийдэх ёстой томоохон асуудал биш, нийт иргэдийн асуудал.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

АТАР ХЭВИЙН БООВ

Ширхэгтэй дээдийн дээд гурилыг Монгол шар тосоор багсарч, далдуу модны тосонд хайрсан АТАР хэвийн боов.

Монголдоо цор ганц ТОС ШҮҮХ ТЕХНОЛОГИОР ХИЙГДСЭН

- ТРАНС ТОСГҮЙ БҮТЭЭГДЭХҮҮН

9811-1955, 9830-1955

Карзэлэгчийн утас:
9333-9001

Дээд баруун портфелд 09%-18% шиг хурт

ХААН банк

Авах

Зарах

Авах

Зарах

Авах

Зарах

Авах

Зарах

АМ.ДОЛЛАР

ЕВРО

ИЕН

2472.00

2608.00

21.78

2486.00

2673.00

22.12

ФУНТ

РУБЛЬ

ЮАНЬ

3037.00

40.00

360.00

2477.00

2613.00

21.77

2488.00

2696.00

22.49

3058.00

40.47

360.00

3152.00


44.09

365.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710



ЭХЛЭЭД ГИШҮҮДЭЭ БУЦААЖ ТАТДАГ БОЛГОЧИХ...

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

$$\Gamma \vdash \psi$$

...Сонин хэвлэлд
янз бүрийн
яриллагаа өгч,
“Хүн дайрч
алчихаад ял
шийтгэл аваагүй.
Өндөр албан
тушаалд очсон”
гээд л хэнэг ч
үгүй яриад л
сууж байдаг шүү
дээ. Гэтэл тэдний
ярьж, хэлснээр
тэр хүмүүсийг
нь бариад,
шалгаад, хуулийн
байгуулага
нотлоод, ял
шийтгэл оноодог
бил үү. Үгүй шүү
дээ...

хийдэгүү, сэцэл гаргадагүү, хариуцлага алддаг байж эрхэм гишүүд ямар ч шийтгэлгүй. Тэгсэн мөртлюө бусдыг болохоор жаахан хальтирвал түлхих гээд байж болмооргүйсэн. Тэгээд юм л болбол сэтгүүлчид рүү дайрна. Ямар ч баримттай, эх сурвалжтай мэдээлсэн байсан “Сэтгүүлчид худалдагдсан. Намайг гүтгэлээ. Би ёстой тэгдэггүй, амьдралдаа тийм юм хийж үзээгүй, ондөг шиг өөгүй” гээд л дайраад байна. Яг ачир дээрээ хамгийн их бусдыг гүтгэж, гутаан

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

„ ýäéýä, í ýí çç °ðò°ã, l i í áí ë óõààí
øéí áýñyí çç ééèéá áàääàáø áàðääàåæ
àòèä ò eäí á. ðýäýöýð ýó i ðí í áí i
çééääýðéýæ áàéääà èí i í áàöèéí áçòýýéýð
ççýñäýëýí áàðääæ, ýðäýi òäèéí i àòåí òuá
i eí i í eéòýä ñóðòàë÷eäo, õ°ð°í á°
i ðóóëàá÷, i àòåí ò ýçýi øèä÷ õí , ðúí
óóëçâàðúä òí áí ðóí é áí eäí õ, áàäí û óëñ
i ðí óóäää l i í áí ë ýðäýi òäèéí áçòýýé,
áçòýýäýöçç i eäá ñóðòàë÷eäí òáí eóëàö
àæëûä çí õëí áàéääóóëäàë l àí àé
ýðäýi òäèéí áçòýýé çí ýò ççéé áí eí .

28/2

ЧУК
ЧУК

Дугаарын 60 мэр

Зөв хэвшил тогтооё

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Түүгээр ч бараахгүй элэгний хавдартай, элэгний хатуулалтай өвчтөнд элэг шилжүүлэн суулгах хагалгааг дэмжих төслийг хэрэгжүүлж, элэгний өвчлөлөөр шаналж буй зарим хүмүүст үнэ төлбөргүй мэс засал хийхээр болсон. Гэх мэтчилэн багагүй үр дун гарч байгаа юм. Тэгвэл одоо элэгний асуудалтайгаа зэрэгцүүлээд ходоодны хорт хавдрын өвчлөлийг бууруулахад анхаарах шаардлагатай болоод байна. Манай улс ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд хоёрт жагсаж буй. Хуучин бол Япон улс бараг 40 орчим жилийн турш ходоодны хорт хавдрын өвчлөлөөр дэлхийд тэргүүлж байсан гэдэг. Гэтэл энэ орон суулийн жилүүдэд гуравдугаар байранд орж байгаа нь хавдрын өвчлөлийг бууруулахад анхаарч эхэлсэн гэсэн уг. Гэтэл манай улс 100 мянган хүн амд 32.9 орчим тохиолдол гэж үзэхэд гурван сая хүн амдаа харьцуулахад жилд 600-700 орчим хүн ходоодны хорт хавдартай хэмээн оношлогдож байна гэсэн уг. Үүний 70 орчим хувь нь хожуу үе шатаандaa оношлогдож тухайн жилдээ 50-аас дээш хувь нь нас барж байгаа талаар эмч, мэргэжилтнүүд хэлийг байгаа юм. Түүгээр ч бараахгүй суулийн жилүүдэд манай улсад хавдрын өвчлөлийн насжилт харьцаангуй заплуужиж байгаагийн зэрэгцээ эрэгтэйчүүдэд 50-60 насанд их тохиолдож байгаа нь ид хөдөлморийн насандаа өвчилж, нас барж байна гэсэн уг юм. Тиймээс ХСҮТ-оос “Элэг бүтэн Монгол 2” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхээр болжээ. Хүнсний аюулгүй байдал, хеликобактер, амьдралын буруу хэв маягаас үүдэн ходоодны шархтай, хавдартай болж буй хүний тоог барихын тулд дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэж байна. Түүгээр ч бараахгүй БНСҮ-ын эмч нартай хамтран ходоодны хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх, эмчлэх тал дээр хамтран ажиллахаар болж байгаа юм билээ. Тэгэхдээ эрүүл мэнддээ анхаарал тавих нь иргэн хүний үүрэг. Өвдсөн үедээ эмчид хандахын оронд өмнө нь анхаарал тавьж, улиралд нэг удаа үзүүлчих л хэрэгтэй юм. Хамгийн гол нь ходоодны хорт хавдрын эх үүсвэр нь хелико бактер. Гэтэл суулийн жилүүдэд Монголчуудын дунд энэ бактерын халдвэр өргөн тархаж байгаа ч цэгцэрсэн, нэгтгэсэн судалгаа хангальттай хийгдээгүй байна. Монгол, Япон эмч нарны хийсэн суулийн судалгаагаар насанд хүрсэн хүмүүсийн бараг 60 орчим хувь нь хелико бактерын халдвартай гэж гарсан байна. Тиймээс нэн яаралтай хелико бактерын халдвэр авах замыг таслан зогсоох, халдвэр авсан бол эмчлэх асуудлыг яаравчлах хэрэгтэй юм. Үрьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай л гэсэн уг. Хелико бактерын халдвэр авах олон янзын зам байдаг юм билээ. Жишээ нь, үндны усны бохирдол эсвэл аяга, тавгаар дамжих ч юм уу. Мөн нэг гэр бүлийн гишүүдээс бие биедээ халдах гэх мэтээр янз бүрийн замаар халдвэрладаг гэдэг. Үүнд монголчуудын хүүхдээ хооллодог уламжлалт арга орж байна. Учир нь хүүхдээ бор хоолонд оруулах гэж эцэг, эх амаараа дамжуулан хооллодог. Тэгэхээр энэ нь тухайн хүүхдэд хелико бактер дамжих гол нохцэл болдог юм байна. Яагаад хүүхдийн хооллолт дээр яригдаж байна вэ гэхээр Япон улсад хийгдсэн судалгаа байдаг аж. Япончууд хүүхдийг мөн багад нь бор хоолонд оруулахдаа мөн амаараа дамжуулан хооллодог байсан аж. Жишээ нь, загасны ясыг салгахын тулд ээж, авв нь заавал амаараа шалгаж байж өгно. Гэтэл нэг, хоёр настай хүүхдэд дархлал бүрэн тогтоогүй байдаг учраас халдвэр авах магадлал ондөр байдаг. Энэ нь удаан хугацаагаар хадгалгаждаж явваад амьдралын явцад ходоодны үрэвэл үүсгээд цааш хавдар үүсгэх нөхцлийг бүрдүүлиж байгаа юм. Энэ талаар нотолсон зүйл байдаг. Хүмүүсийн соёл, дадал хэвшил сайжраад эхлэхээр хүүхдийг шүлслээрээ дамжуулахгүй хооллоод ирэхээр хүүхдэд хелико бактер дамжих нь буурч байгаа нь мэдэгджээ. Үүнд давсны хэрэглээ ч ордог байна. Тиймээс иргэн бүр энэ байдалдаа анхаарал тавьж, хелико бактертай эсэхээ эрт оношуулж, өөрийгөө ч, үр хүүхдээ ч хамгаалж, амьдралдаа зөв хэвшил тогтоомоор байна. Тэгж чадвал дэлхийд тэргүүлээд буй ходоодны хорт хавдраас сэргийлэх боломж бурдэх нь.




ДЭЛХИЙ

**Доналд Трамп
Р.Эрдогантай
утсаар яржээ**

Б.СУМЬЯА

АНУ-ын Еронхийлögч Доналд Трамп Турк улсын Еронхийлögч Ресеп Тайип Эрдогантай анх удаагаа утсаар яржээ. "Daily Sabah" сонинд мэдээлснээр хоёр Еронхийлögчний яриа Туркийн орон нутгийн цагаар 00:05-д эхэлж 45 минут орчим үргэлжлэн "эерэг дулан" уур амьсгалтайгаар дуусчээ. Туркийг үргэлжлүүлэн дэмжиин гэдгээ Д.Трамп илэрхийлсний сацуу терроризмийт хийх тэмцэлд оруулж буй Турк улсын хувь нэмрийн ондроөр үзүүлж байгаагаа илэрхийлээ гэж Цагаан ордон мэдэгдэв. "Еронхийлögч Трамп Турк улсын стратегийн түүни, НАТО-гийн холбоотны хувиар дэмжинэ гэдгээ илэрхийлсний сацуу "Палын улс"-тай тэмцэхд Туркийн оруулж буй хувь нэмрийн ондроөр үзүүлж байгаагаа дахин мэдэгдэв" гэж Цагаан ордын мэдэгдэлд өгүүлжээ. Мөн хоёр Еронхийлögч АНУ-Түркний эртний нягт харицаа болон терроризмын аливаа хэлбэртэй хийх тэмцийн тухайд санаалаа солилцон ярилцсан байна.



Б.ДАВААХҮҮ

ОХУ-ын Еронхийлögч В.Путиныг эсэргүүцэгч гэж тодотгож болохуйц улстөрч 35 настай Владимир Кара Мурза бусад хорлогдоноы улмаас эмнэлэгт хүргэгджээ. Тэрбээр эдүгээ үзэлж, сэхлийн заагт буй бөгөөд эрхтэн дутагдайл орсон тухай эхнэр нь сэтгүүлчдэд мэдээлсэн байна. Мөн ямар нэгэн үл мэдэгдэх бодист хордсон гэж оношилгэжээ. Өмнө нь Кара Мурза хордож байсан ч, тухайн үед амь нааснаас нь холуулж онгорч байсан гэнэ. В.Путиныг шүүмжлэгч тэрбээр АНУ руу ялахынхаа өмнөхөн ийнхүү хордож, түргэн тусламжийн тэрэгээр эмнэлэгт хүргэгдсэн байх юм. Владимир Кара Мурза арчилын дэмжигч "Нээлттэй Орос" нийтэмзэгт ажилладаг байжээ. Эмнэлэгт хүргэгдэг шоноо эхнэр, хоёр хүүхдийнхээ хамт хадмындаа байсан бөгөөд ВашингтонДС хот руу нисэхээс

ердөө хөдхэн цагийн өмнө гэнэт л биенийн нь байдал муудаж эхэлсэн байна. Ардчилын төлөө идэвхитэй тэмцэгч, мөн сэтгүүлч тэрбээр 2015 онд мөн л хордсон гэх шалтгаанаар эмнэлэгт хүргэгдэж, хоёрсын хугацааг эмнэлгийн орон дээр онгөрүүлж байжээ. Тухайн үед бөөрийн архаг дутагдайл орсон байсны зэрэгцээ ниснаас нь хүндметалгүйнээр агуулж байх юм. Мөн "Харамсалтай нь маш олон хүн миний нохрийн хийж буй үйл ажиллагаанд дургүй. Тиймээс яг үнэндээ түүний хэн нэгэн хордуулсан байлаа ч, үнэн зөвлөж нь тогтооход туйлын бэрх" гэжээ. Хамгийн гол нь Кара Мурзагийн суулийн үед хийж хэрэгжүүлсэн ажил нь сонирхол татна. Тодруулбал, тэрбээр 2015 онд Кремлийн ойролцоо найз бүсгүйтэгээ зугаалж яваахдаа буудуулж амлаан дотны найз, сөрөг хучний либералистич Борис Немцовын талаарх баримтыг Оросыг тойрон аялж цуглуулж байжээ. Тэр бүү хэл, эмнэлэгт хүргэгдэх уедээ 33 настай залуу бүйлийн дутагдалд

В.ПУТИНЫ БАС НЭГ "ДАЙСАН" ҮХЛИЙН ИРМЭГТ БАЙНА

орж, цуснаас нь дээж авч шинжилжээд хунд металл ондөр агууламжтай гарч байжээ. Түүний дараа ОХУ-ын Мөрдөх хороонд хэн нэгэн санаатайгаар хордуулсан эсхийн шалгах хүсэлт тавьсан ч, хэрэгсээгүй байна. Харин Кара Мурза эхнэрийнхээ хамт хэн нэгэн оорийг нь хорлосон гэдэгт бат итгэлтэй байжээ. Тэрбээр оорюү ч энэ тухайгаа хэвлэлд өгсөн ярилцлагадаа илэрхийлж байсан аж. Тухайлбал, 2016 онд өгсөн ярилцлагадаа "Би 33 настай эрүүл саруул залуу байлаа. Гэтэл 24 цагийн дотор л мийн бүх дотор эрхтнүүд ар араасаа өвдэж эхэлсэн. Зүгээр нэг тохиолдлын хэрэг биш байгаа биз дээ" хэмээж, оорийг нь улс төрийн зорилгоор хордуулж алах санаархал хэн нэгэнд бий гэдэгт "ямар ч эргэлзээгүй" итгэлтэй байгаагаа илэрхийлж байна. Ямартай ч, арчилын төлөө тэмцэгч, сэтгүүлж Кара Мурза энэ сарын 2-нд орон нутгийн эмнэлэгт хүргэгдсэнээс хойш амьсгалын аппаралтай ухэл амьдралын заагт байгаа аж. Түүний эхнэр Евгения Кара Мурза Франци Израильн шинжилгээний хүрээлэн руу дээж явуулж шинжилүүлэхээр төловлюөд байгаа гэнэ. Өөрийн орны хүмүүст итгэхгүй байгаа нь ч учиртай. Түүний 2015 онд хордож үед нь ч тээцэнд хэн ч итгэхгүй байх юм. Өөриөр хэлбэл, хордлогын шалтгаантайгаар эмнэлэгт хүргэгдэх уедээ 33 настай залуу бүйлийн дутагдалд

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

ХҮҮХДИЙН АСУУДЛЫГ ШИЙДЭХ ГАРЦЫГ ЭРЭЛХИЙЛЭВ

Н.БАТЗАЯА

Манай улсад 2016 онд насанд хүрээгүй 360 хүүхэд гэмт хэрэг үйлдсэн гэх харамсалтай мэдээллийг холбогдох албанын тайлан хурлаараа дамжуулан мэдэгдсэн. Хүүхэд гэмт хэрэгт холбогдоно, хулгай хийсэн, бүлэглэн хүн дээрэмдсэн, танхайрсан, хичээл номноосоо заварсдан зэрэг олон мэдээлэл өнөөгийн нийгэмд хэвийн зүйл шиг л яригдаа болов. Гэхдээ хүүхдүүдийн зан толов, хүмүүжилд гэр булийн орчин нөхцөл, эцэг, эхийн хайр халамж ихэхэн нөлөө үзүүлдэг талаар холбогдох мөргөжилтийн зөвлөдөг. Тэгвэл тус салбарынхан очигдөр эрдэм шинжилгээний

хурал зохион байгууллаа. Тус хурлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, МУБИС-ийн Нийгмийн ажил, арга зүйн тэнхимээс хамтран зохион байгуулсан бөгөөд нийт 32 илтгэл хэлэлцэгдсэн. Тухайлбал, "Эцэг, эх нь архины хамааралтай хүүхдийн түгшүүрийнтувшин", "Хүчирхэг нийгэм, хөгжсон хүмүүний хэрхэн бий болгох вэ", "Хүүхдэд оногдуулсан хорих ял эдлүүлж ажиллагаа, тогтолцооны шинэчлэл", "Асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхдийн давуу тал" зэрэг 30 гаруй илтгэлийг хэлэлцсэн юм. Энэ үеэр ГБХЗХГ-ын Хүүхдийн хөгжил хамгааллын газрын дарга Ц.Алтанзаяа "Эрдэм шинжилгээний илтгэлүүдийг бид хүүхдэхамгаалал, хүүхдийн



хөгжил оролцоо, монгол хүүхэд судал гэсэн гурван чиглэлээр авсан. Манай улс суурин болон нүүдлийн соёл иргэншилтэй дэлхийд цор ганц байдаг орон. Соёл, иргэншийн паралелиар авч явж байгаа тохиолдолд хүүхдийн хүмүүжил, хөгжлийн асуудал дэлхийд цор ганц гарч ирэх асуудал байгаа юм. Тиймээс манайд монгол хүүхдийн хөгжил, оролцооны асуудлын шийдвэрээр шилдэг бүтээлүүд, эрэдэлт нохцолд байгаа хүүхдийг урьдчилан сэргийлэх, халамж, асрамжийн газар, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа зуслангиин нэгдсэн хотолбортай талаар хөгжил хамгааллын газрын дарга Ц.Алтанзаяа "Эрдэм шинжилгээний илтгэлүүдийг бид хүүхдэхамгаалал, хүүхдийн

зөвхөн боловсролын байгуулагын асуудал биш. Эцэг, эх, багш, нийгмийн ажилтнууд хамтарч ажиллас эстий. Бид цаашид Засгийн газрын мөрийн хотолборт тусгагдсан хүүхэд хамгааллын хөгжлийн хөтөлбөрийн 2016-2020 бий болгож байгаа. Энэ хотолбортайхөө дагуу дэд хөтөлбөргаргаад хэрэгжүүли" гэв. Энэ үеэр эрдэм, шинжилгээний хуралд илтгэл тавьсан хүмүүстэй уулзаж, ярилцлаа.

T.Цэндсүрэн: Архины хамааралтай эцэг, эхчүүд хүүхдийн ирээдүйд сөргөөр нөлөөлж байна

/МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхлийн эрхлэгч/

-Гэр нь освор насынхын хувьд анхан шатны орчин болох гэр бүйлийн асуудал маш чухал байдаг. Өнөөгийн нийгмийн орчинг харахар эцэг, эхчүүд хүүхдийнхээ санхүүгийн асуудал, эдийн застгийн хэрэгцээг шийдэхэд анхаарахаа бин тухайн хүүхэд хэнтэй харыаж, хэн болж төлөвшиж байна, ямар асуудал байна вэ гэдэгт анхаарахаа больсон. Өөриөр хэлбэл, сургууль, зөвхөн энэ асуудлыг даатгаж байна. Освор насын хүүхдүүдийн нийтлэг төрхийн харвал 2014 оноос хойш энэ насын хүүхдүүдэд чиглэсэн судалгааны ажлууд хийгдсэн байна л даа. Жишээлбэл, освор насын монгол хүүхдийн давуу чанарын үзэлж судалгаа байна. Энэ судалгаа МУБИС-ийн Нийгмийн ажилтны арга зүйн танхим дээр хийгдсэн. Тэгэхээр судалгааны үр дүнд хэд хэдэн ноцтой асуудлууд гарч ирсэн. Өсвөр насын хүүхдүүд маш их асуудалт байна. Шударга бус хүн болж төлөвшиж байна. Мөн освор насынхаяа хүүхдийн дэргэд эцэг, эхчүүд архидах нь их байна. Гэр будтоо архи уудаа. Архинаас хамааралтай эцэг, эхтэй хүүхдүүдийн түгшүүрийн төвшин их байдаг. Суур төвшин үүсээд ирэхэр хүүхдүүд хичээлдээ анхаарал нь сайн төвлөрдөгүй, наиз нөхөнөос зайгаа барьж эхэлдэг. Үүнээс болж сэтгэл санааны дарамттай, байгын стрессийтэй болдог. Энэ бүх зүйлс монгол хүүхдийн ирээдүйн хөгжилд маш их сөрөг нөлөөтэй байна гэдгийг судалгааны үр дүн харуулсан.

Ц.Алтанзаяа: Хүүхдэд хамгааллын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

/ГБХЗХГ-ын Хүүхдийн хөгжил хамгааллын газрын дарага/

-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2016 оны дөрөвдүгээр улиралд Монголд үйл ажиллагаа явуулдаг асрамж, халамжийн газарт хүүхдийн эрх болон хүүхэд хамгааллын стандарт хангах чиглэлээр шалгайлт хийсэн. Шалгалтаар 32 асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа нь гарсан. Үүнээс түрэв нь улсын, үлдээс нь хувь болон олон улсын шинж чанартай асрамжийн газар байсан. Мөн бид шалгалтынхаа хүрээнд МУБИС-ийн багийн наартай хамтарч хүүхдийн хөгжлийн давуу чанарын үнэлгээг хийсэн. Энэ судалгаанд 10-14 настай освор насын хүүхдүүдийн хөгжил, оролцоо, төлөвшийг бусад хүүхдүүдийнхээд харыцуулж судалсан. Судалгаанаас освор насын хүүхдийн хүмүүжилд хөгжлийн орчин, нийгмийн оролцоо, идэвх, багш сургалт хүмүүжүүлэгчдээс их зүйлийг шаардаж хүлээж байдаг нь харагдсан. Бид цаашид Засгийн газрын мөрийн хотолборт тусгагдсан хүүхэд хамгааллын хөгжлийн хотолбөрийг хэрэгжүүлнэ.

Ш.Батдэлгэр: Хүүхдүүд эрүүл орчинд амьдарч чадахгүй байна

/Нийгмийн эрүүл тэндийн хүрээлэн/

-Хар тугалга хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Ялангуяа сэтгэг бодох чадвар, ой тогтоогтод мугаар нөлөөлдөг. Судалгааны дүнгээс үзэхэд хүрээлэн байгаа орчны хорс, ус, агаарын хар тугалга хүүхдийн овчилоолд тодорхой хэмжээгэр нөлөөлж байна гэсэн судалгааны дун гарсан. Харин цусанд агуулагдаж хар тугалгын агууламж нь ДЭМБ-ын зөвлөмжид заасан хэмжээнээс илүү байна гэсэн судалгаа манай монгол хүүхдүүдийд хийдсэн. Тэр дундаж Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт амьдардаг хүүхдүүдийн цусан дахь сахарын хэмжээ зөвшөөрөгдх хэмжээнээс илүү байсан. ДЭМБ-ас хүүхдийн цусанд 5 мкг/дп хар тугалга байвал хортой гэж үздэг. Харин манай улсын хүүхдүүдийн цусанд дунджаар 16-19 мкг/дп байгаа юм. Тэр дундаж гэр хорооллын хүүхдүүдийн цусан дахь хар тугалгын агууламж их байсан. Эдгээр хүүхдүүдийн амьдардаг хашаанд нь гарааш, нүүрснээс гардаг үнсэнд тодорхой хэмжээгэр хар тугалгын агуулагддаг. Энэ бүхэн хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх үндэс нь болдог.

ОНЦЛОХ ХУУДАС

Ӵүй ёү Ӵүй ау?

КОММУНИСТУУДАД ЭЭЛТЭЙ ДҮҮРГҮҮД



Х.НОРЖИН

“Хэн нь хэн бэ”
булангийнхаа
энэ удаагийн
дугаарт
нийслэлийн
Багануур, Налайх,
Багахангай
дүүргийн Засаг
дарга нарыг
онцолж байна.

...Захирагч нь
Засаг даргаасаа
хамаарахгүйгээр
хотын нийгмийн
асуудлыг хариуцна,
Засаг дарга нь
Захирагчаасаа
хамаарахгүйгээр
дүүргийнхээ ажлыг
хийн гээд Налайхын
газар нутгийг
дүүргийн газар нутаг,
хотын газар нутаг гэж
хоёр хуваах тухай
асуудал яригдаар
байгаа. Тэгэхээр
Захирагчаар Ш.Хаан,
Засаг даргаар нь
Ч.Раднаабазар
ажиллаж буй. Эрхэм
Засаг даргын тухайд
улс төрд шинэ хүн. Гэв
гэнэтхэн л ийм нэр
сонсогдох болсон...

ДҮҮРЭГ ЦААШАА
Ц.САНДАГ-ОЧИР

Муу нэрийг хусавч үл
ариллах тодотголдоо
үе ўе шанаалж суудаг байж
мэдэх эрхэм бол Багануур
дүүргийн Засаг дарга
Ц.Сандаг-Очир. Орон нутгийн

бүх шатны сонгуульд намаа
авч гарсан гавьяагаа эдлэн

дүүргийн Засаг даргаар
хоёртоо томилогдсон

түүнийг “зодоонч”, “газрын
наймаачин” гэх “шошго”

цаг ургэлж дагах. Мань эр
2008-2012 онд дүүргийнхээ
Засаг даргаар ажиллах байх
үедээ газрыг албаны дарга
Х.Хишигбадрахын хамт албан
тушаал, эрх мэдлээ урвуулан
ашигласан тэх хэл аманд ортоон

АТГ-т хоёр жил байцаагдаж
үйлээ узсэн түүхтэй. Үүнийг
эс тооцвол Сандаг-Очир
нёён бас ч гэж эрийн
хүгархай, нүжигтэй эр юм
гэнэ лээ. Түүний ус төрийн
боловд хувь хүний намтыг
сонирхох аваас “Тэнгэр”

дээд сургуулийг тогссон,
философич, нийгмийн ухааны
багш мэргэжилтэй, 2001

оноос Багануур дүүргийн
IV дүгээр хорооны нийгмийн
ажилтан, Багануур дүүргийн

Засаг даргын Тамгын газрын
мэргэжилтэн, Багануур
дүүргийн МАН-ын дэд дарга,

2000 оноос Багануур дүүргийн
Засаг даргаар ажиллаж буй

гэсэн ганц өгүүлбэрт багтах
аж. Асуудлыг нөгөө өнгөөс

нь харвал, дүүргийн анхан
шатны нэгжээ Засаг дарга
болжлоо өсч дэвжих болдгүйг
намынхаа запуст биеэр

харуулж явваа улсторч. Эдгүй
түүнийцээжийн мухарт дүүрэг
цаашаа болж, УИХ-ын гишүүн
боловс мөрөөдөл буй гэдгүй
морийцхөд ч бэлэн байна.

Үүнийх нь толөө Багануур
дүүргийн Засаг даргын
Тамгын газар хичээнгүйлэн
зүтгэх биз. Учир нь тэрбээр

циун баригчид төдийгүй
тэднийхээ эхнэрүүдийг
ивээлдээ авч багаа бүрдүүлсэн

гэлцдэг. Бүр хэн ч үгнээс нь

гараагчүй байх сайн талтай
ч байж мэднэ. Гэхдээ тэр

юу чаддагаа дүүргийнхээ
иргэдэд харуулахаар хичээж

яваагаа сэргүүлчидэй саяхан
хуваалцсан юм. Тэрбээр

2008 оноос дүүрэг, орон

нүүгийн батлагдсан хөрөнгө

оруулалтын ажлуудыг тухайн

онд нь багтаан хийхэд анхаарч

ажиллаж ирсэн гэнэ. 2017

оны тухайд эдийн засгийн
хувьд хүнд байгаа учраас

батлагдсан төсөв мөнгөндөө

багтааж, хөрөнгө оруулалтын

ажлаа тасралтгүй явуулжин

зэрэгцээ ямар нэг дэд

бүтэцгүй, тог цахилгаангүй,

уулын бэл, гуу жалгаа зэрэг

төвөгтэй байршилудыг эхний

эзлжинд цахилгаан дэд

бүтэц, худаг устай болгоход

онцгой анхаарна хэмээсэн нь

багануурчудын сэргэлийн

үтсүүг ихээхэн хөндсөн байх.

НИЙСЛЭЛ РҮҮ ГҮЙДЭЛТИЙ

Ч.РАДНААБАЗАР

Налайх дүүрэг засаг
Захирагчын нэгжийн

хувьд үл ойлгогддог, оөрөөр

хэлбэл толгой эргүүлсэн

засаглалтай газар. Засаг

даргатай бас захирагчтай.

Энэ хоёр удирдлагын

хэлбэл талаар налайхчуд

онөө хэр маргалдаасаар

байдаг юм билээ.

Ямартай ч Захирагч нь

Засаг даргаасаа хамаарахгүйгээр

хотын нийгмийн асуудлыг хариуцна,

Засаг дарга нь Захирагчаасаа

хамаарахгүйгээр дүүргийнхээ

ажлыг хийн гээд Налайхын

газар нутгийг дүүргийн газар

нутаг, хотын газар нутаг тэгж

хоёр хуваах тухай асуудал

яригдаар байгаа. Тэгэхээр

Захирагчаар Ш.Хаан, Засаг
даргаар нь Ч.Раднаабазар

ажиллаж буй. Эрхэм Засаг

даргын тухайд улс төрд шинэ

хүн. Гэв гэнэтхэн л ийм нэр

сонсогдох болсон. Түүнийг

“Оюуны-Ундрат”-гийн С.Огтоонбаярын

халаасны нохон гэж хардах хүн олон.

Гэхдээ тэр Налайхын иргэн

болсон атлаа Улаанбаатараас

ажилдаа явдаг гэнэлээ. Дагаж

очсон албан тушаалтнууд нь ч

ялгаагүй. Нутагшиж өгөхгүй

байгаа малыг мөдхөн гүйгээд

явчихаа хэмээн монголчууд

ярьдаг даа. Түүгээр бол мань

хүн дөрвөн жилийг арайхийж

авчихаад нийслэл рүүгээ

гүйж одно гэсэн уг. Ийм нэг

залуу нийслэлийн Налайх

дүүргийг засаглаж буй.

Ч.Раднаабазарыг Налайх

дүүргийн Засаг даргаар

батламжлахад мань хүн

“Итгэл хүлээж, дүүргийн

Засаг даргаар томилгдсондоо

баяртай байна. Бидний өмнө

байгаль орчинд ээлтэй эко

орчин бүрдүүлж, Налайхыг

жилийг хот болгох олон

асуудал тулгарч байна. Энэ

бүтгийг ээлж дараатайгаар

зохион байгуулж, ажлаа

шуурхай эхлүүлэх бодлолтой

байна” хэмээн нүүрэндээ

инээмсэглэлтодрууланогоулж

байсан юм. Харамсалтай

зодолдсоор хавартай золгох
гэж байна. Төр, засаг тэдгээр

нүүрсчдийг гар агаар нүүрс

олборлогч гэх томъёололд

багтаан нийгмийн халамж

үзүүлэх гэсэн боловч унэн

хэрэгтээ тэд эзэнд зүтгэдэг

учраас яаж ч чадахгүй байгаа

юм билээ. Тиймээс эрхэм

засаг поён том ярихаасаа

өмнө эзэн, зарц хоёрынхоо

учырг олоодховол олон арван

хүний амь нас эрээдэг байдал

зогсох сайн талтайсан.

КОММУНИСТ
С.ЭРДЭНЭБАЯР

Xүн амынхаа тоогоор
Багахангай дүүрэг
нийслэлд хамгийн сүүлд

бичигддог. Хорооны хүн

амаас ч цөөн хүн амтай

гэж ойлгож болно. Гэхдээ

коммунистуудын хороолол

гэдгийг мартаак болохгүй.

Тэнд ардчиллын цэнхэр тут

хийсхэв тавилангүй гэцээх юм

билээ. МАН гэсэн шошготой

л бол хэн ч байсан дэмжэдэг

нугат бололтой. Нэгэн цагт

байгаль хамгаалагч хийгээд

ЧУХАЛ СЭДЭВ

Ч.ГАНТУЛГА: ЭХНИЙ ЭЭЛЖИНД ЗОГСОНГИ БАЙДАЛД БАРИЛГЫН САЛБАРАА ХӨДӨЛГАЖ, ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ

Төгсгэл.

Түрүүч нь I нүүрт

Буруу зүйлүүдээ засах цаг нь нэгэнт ирсэн. Бид утаа гэж ярихаасаа омно бий болгоод байгаа гол шалтгааныг нь судалж үзэх хэрэгтэй гэж үзэж байгаа. Сүбэктыв талаас нь авч үзвэл түүхий нүүрс, хог хаягдлыг шатааж байгаа явдал яах аргагүй мөн. Нийслэл хотын агаарын бохирдлын 70 орчим хувь нь үүнээс үүдэлтэй. Объектив талаас нь үзвэл өнөөгийн нийтэй эдийн засгийн дорой байдал, амьжирааны төвшин орлогын эх үүсвэр өсөх боломжгүй хэмжээнд очсон, эдийн засгийн нохцел байдалт тулгарсан гэх мэт сөргөөр нөлөөлхөн хүчин зүйл олон байна. Бас нэг зүйлийг энд дурдахгүй байж болохгүй. Тухайлбал, 1990-ээд оны дунд үеэс нийслэл рүү чиглэсэн их нүүдэл хөдлөгөөний зохион байгуулж чадаагүй тухайн үеийн эрх баригчдын алдаа юм. Үндсэн хуулианд хүний эрх, эрх чөлөг тунхагласан хэдий ч шилжин ирэгсдийн нийгмийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, ажлын байр, орон сууц, сургууль цэцэрлэг төрийн үйлчилгээг сайжруулах тогтолцоог орхигдусан. Тэр дундаа онгорсон хугацаанд хийсэн хот төловлөтийн асуудлыг ярих хэрэгтэй болно. Үндсэн хуулийг иргэн ажиллах, амьдралгазраа чөлөгт сонгох эрхтэй хэдий ч засаг захирагаа, орон нутгийн тухай хуулиудаар асуудлыг зохицуулаад явах боломж байсан. Ер нь бол Үндсэн хуулияа зөв тайлбарлаж ойлгох нь ус агаар мэт чухал шүү дээ. Сүүлийн 10-аад жилийн шилжилт

хөдлөгөөнөөс үүдэн Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн тоо 219 мянган орчимд хүрчихээ. Нийслэлийн иргэд осч байгаа нь эдийн засгийн хувьд ч, нийгмийн бодлогын хувьд ч зөрөг үзүүлэлт мөн. Гэхдээ бүгд орон сууцтай, өөрдүнхөө амины сууцыг төловлөтийн дагуу барьчихдад, технологийн шийдвүүдийг ашигладаг байвал бүр ч сайхан шүү дээ. Нийслэлийн Засаг дарга багаад Улаанбаатар хотын Захирагч агаарын бохирдол болон үүссэн нохцел байдалт уялдуулан Улаанбаатар хотын хил хязгаарыг тур хугацаагаар онцгой бүсэд оруулж, шинээр байгын оршин суугчaaар шилжин иргэдийн хязгаарлах тухай мөн агаарын бохирдлын хэмжээгээр нь тодорхойлж, нийслэлийн дөрөвн бүсэд хуваан тухайн бүсүүдэд агаарын бохирдлыг буруулах ажлын төловлогое гаргаж, шат шатанд нь хэрэгжүүлж эхлээд байна. Мөн Үндсэн Аюулгүй Байцлын Зөвлөл хуурайдаж нийслэлээс гарсан санаачилга, хэрэгжүүлэх ажлуудыг дэмжин гамшигийн хэмжээнд хүрээд байгаа агаарын бохирдлыг буруулах тал дээр зөвлөмж гарган ажиллаж байна. Улаанбаатар хотыг дөрөвн бүсэд хуваасантай холбогдуулан төвийн бүсэд түүхий нүүрсийг түлүүлэхгүй байх, яндан шинээр нэмэгдүүлэхгүй байхар ажлуудыг төловлож байна. Цаашлаад, одоо байгаа яндангуудаа цэгцэх, заримыг нь хаах арга хэмжээ авах, цахилгааны шөнийн тарифыг тэглэх зэрэг захирамжуудыг гаргасан. Ярилцагын эхэнд хэргэжээд эхэлээ. Мөн үн дотор бидний ярьж байсан

дагуул хотууд байна. Налайхын аж үйдвэрлийн парк байна. Одоо Төв аймагт шинэ нисэх онгоцын буудал ашиглалтад орж, хүлээлгэж өгөх гэж байна. Шинэ нисэх онгоцын буудлыг дагаад 10-15 мянган айл, өрхтэй дагуул хот байгуулах боломжтой. Хүй долоо худагийн "Монгол наадам" аялал жуулчлалын цогцолборыг дагаад 10-15 мянган айл, өрхтэй үзэр үйлчилгээнээс авахаацаад бух зүйлийг нь шийдсэн хороолол, хотчуунудыг барих төслийн хэрэгжээд явж байна. Энэ ажлыг хийжээд эхэлж байгаа нь цаанаа салбар бүрт иргээд ажлын байраар хангах боломж нь нээгдэж огно. Мөн эдийн засгийн өргөлтэд оруулах ач холбогдолтой. Хүмүүс ажилтай болж, тодорхой хэмжээнд орлогын эх үүсвэртэй болоод ирэхээр ямар орчинд амьдарч байна вэ гэдээ анхаарна, харна, бодно. Ногоё талаасаа цахилгааны шөнийн тарифын тодорхой хувийг тэгэсэн санал, санаачилгүүд маань ажил хэрэг болох боломж нээгдэнэ. Орлого нь нэмэгдээд ирэхээр нүүрс түүж байгаа айлууд монгол инженерүүдийн гараар бүтсэн халаагууруудыг авч тавиад, дулааныхаа асуудлыг цахилгаанаар шийжээд эхэлнэ. Энэ мэтээр асуудалд ул суурьтай хандаж, гарал үүсэлээс нь эхлээд л шийдээд явах нь зөв юм гэдгийг бүгд ойлгосон байх. Бид тулгамдаж байгаа асуудлыг олон жил шийдэх гэж үзлээ, ярилаа, байдал улам л дорийтсон. Сайжирсан зүйл цөөн байна. Асуудал хэээд байдаг, шийдэж ч бодлог. Гэхдээ бид жаахан асуудал гараад ирэхээр

улстөрждөг байдлаа болимоор байна. Тэр дундаа утааны асуудал дээр. Энэ бол Монгол Улсын иргэдийн үр удам, генийн асуудал яригдаж байна. Бидний ирээдүй болсон хойч үеийн эрүүл мэндтэй холбоотой асуудал шүү дээ. Уг нь эрүүл, аюулгүй орчинд амьдрал эрх нь Үндсэн хуулиар хамгаалгасан байгаа. Энэ эрхийг хангахын тулд бид цэгцэй, шат дараатай алхмуудыг хийж байж үр дүнд хүрнэ. Дөрөв, найман жилийн дараа, 2020, 2024 он гэхэд утаа 50-60 хувь бууруулах боломж байгаа. Ажлын үр дүнгүүд гарахаа ёстой. Тэгэхийн тулд бид ажиллаж байна.

-Одоо хэрэгжүүлж эхэлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн зорилтуут хугацааны юм биш ўу. Мэдээж урт хугацаанд аа бид утаанаас салах л байх. Харин ойрын хугацаанд утааны эсрэг ямар ажил хийж, хэрэгжүүлж юм бэ. Эсвэл урт хугацааны зорилтууд билэлтээ тэвчээд сууж байх ўу?

-Нийгмийн хамарсан том асуудалд бол ул суурьтай хандах ёстой. Богино хугацаандаа ямар ажил хийх юм, үр дүн нь шийж байх юм. Урт хугацаандаа бид юу хулээж байгаа юм, юу үзлэх юм, ийн хөөр чиглэлийг л барьж ажиллах ёстой. Богино хугацаанд хийх ажил гэвэл Үлаанбаатар хотыг бүсчилнэ. Жишиг нь, нэгдүгээр бүсэд бол хамгийн гамишгийн хэмжээнд хүрсэн газрыг хамруулж байгаа. Цаашлаад, хоёр, гурав, дөрөвдүгээр бүс гээд хуваас юм. Дөрөвдүгээр бүсэд бол төвийн хэсгийн хороолол багтана. Энэ мэт бүсчилсэн зураглал гарсан байгаа. Бид хурал хийгээд, шийдэх хэрэгтэй. Барилгын компаниудын санхүү мөнгийг ч шийдэж өгөх хэрэгтэй юм. Барилга барьсан хойно орон сууц худалдаж авдаг ирэд нь байх ёстой. Тэгэхийн тулд ирэд ажилтай, орлоготой баймаар. Энэ бүх асуудлыг цогцоор нь шийдэж явахын тулд бид урт хугацааны төловлөгөө гаргах ёстой. Дээрээс нь төвийн хэт их төвлөрлийг багасгах зорилготой дагуул хотуудаа байгуулах, хөгжүүлэх, ажлын байр бий болгож явах хэрэгтэй байна. Ингэж байж бид 4-6 жилийн дараа үр дүнг нь харна.

-Урт хугацааны ажил гэхээр орон сууцаар хангах, дахин төловлөтийн асуудлыг ярих болно. Гэтэл ойрын хэдэн жилдээ манай улсад дахин төловлөлт хийх хөрөнгө боломж байгаа билүү. Хөрөнгө оруулалтаа шийдэх хэрэгтэй. Барилгын компаниудын санхүү мөнгийг ч шийдэж өгөх хэрэгтэй юм. Төвлөрлийн төслийн хийх асуудалд бол мөнгөтэй байсан. Томоохон бондууд гаргаж, арвин их мөнгийг босгож чадсан. Энэ бол амжилт. Харин бид юу хийхээ төловлөж байж мөнгө босгосон уу гэвэл угүй. Юунд зарцуулах гэж байгаа юм, үр ашигтай төслүүд нь юу юм. Яг өнөөдөр нийтэдээ тулгамдаж байгаа суурь асуудлыг шийдэж чиглэсэн төслүүдээ хөрөнгө оруулалт хийж чадсан уу гэвэл чадаагүй л гэнэ. Ажлын байрьг олон ниймж чадсан билүү, угүй. Одоо эхнээсээр ор зээлээ төлөх болгихлоо. 580 сая алдьларыг ирэх сардаа багтааж төлөх гэж байна. Одоогийн Засгийн газар энэ ерийг төлөх гэж чамгүй л ажиллах байгаа. Яах вэ, онгорсон жилүүдэд барилгын салбарт хөрөнгө оруулсан уу гэвэл тийм. Гэхдээ хөрөнгө оруулахадаа бодлогогүй хандсан. Эрэлт, хэрэглэгч талаа дэмжих ўу. Эсвэл үйлдвэрлэл талаа дэмжих ўу гэдгээ маш зөв тооцог ёстой байсан. Үнэ тогтвэржүүлах хөтөлбөрийн хүрээнд хэдэн компани, бизнесмэнийг дэмжээд, хүүгүй шахам зээл өгсөн. Тэр зээлийг авсан хэдэн компани хол дээрээ босood, цаашаа арилжаа ниймаагаа хийгээд л явсан. Жишиг, дунд үйлдвэрлэгчид

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ НЬ 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГААР ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ"-НИЙ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

Захиалагч: Зам, тээврийн хөгжлийн яам
Төндер шалгаруулалтын төрөл: Зөвлөхийн үйлчилгээ
Төндер шалгаруулалтын дугаар: ЗТХЯ/20170003
Санхүүжилтийн эх үүсвэр: Улсын төсөв
Төсөвт өргөт: 10,000,000.00 тогрог
ХАА-ны мөрдөх журам: Зөвлөх үйлчилгээнэйн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам
Цахим төндер эсэх: Угүй
Гадаад этгээд оролцох эсэх: Угүй
Зарлагдсан огноо: 2017

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Зам, тээврийн хөгжлийн яам нь 2016 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх, зөвлөх үйлчилгээнэйн гүйцэтгэгч сонгон шалгаруулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүснэгтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь [ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГААР ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ] болно.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь ТБОНӨХБАҮХАТ Хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг хавсарган ирүүлнэ.

- Үнднд:**
- Байгууллагын ерөнхий танилцуулга, байгууллагын гэрчилгээний хуулбар,
 - Ижил төстэй ажлын түршлэгийн талаарх мэдээлэл,
 - Зөвлөх хуулийн этгээдийн ажиллах боловсон хучийн чадавхийн талаарх мэдээлэл, /голлох ажилтнуудын ур чадварын мэдээлэл, түршлэгийн хуулбарыг хавсарган ирүүлнэ.
 - Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл, /сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, татварын байгууллагын тодорхойлолт/
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцох боломжтой эсэх, /зөвшөөрөн/

Нээлтэл тайлбар: Сониифхсон этгээд лэдүүлгээ 2017 оны 02 дугаар сарын 17-ны 17:30 цагийн дотор ирүүлнэ ўу.

Монгол Улс, Улаанбаатар-14251, Сүхбаатар дүүрэг, Чингэсийн өргөө чөлөө-11, Засгийн газрын XIII байр, 1 дүгээр давхар 107 тоот өрөө, утас 62263196 , www.mrtd.gov.mn

Хүчингүйд тооцов

Далай овогтой Бөхбаатар Төв аймгийн Сэргэлэн сум зөрүү донгийн ам гэрчилгээний дугаар 18669284229671, улсын бүртгэл 0004502220 тоот бүртгэлтэй Зга талбайтай үйлдвэр, үйлчилгээний зориулалттай эзэмшилж гэрчилгээ гээдүүлсэн тул хүчингүй болгов.

Оюунгэрэл овогтой Бумэрдэн ЖЯ850308 мэргэшсэн жолооны

ЧУХАЛ СЭДЭВ

ОРЧИХСОН ХЭРЭГТЭЙ БАЙНА

цохигдоод л гарсан. Уг нь бол барилгын салбарыг дамжсан ээр иргэд орон сууданд ихээр орж, янданг цөөлөх, цаашлаад утааг багасгах зорилготой байх ёстой байсан. Гэвч зорилгодоо хүрч чадаагүй. Багагүй хэмжээний мөнгө зарцууллаа, үр дун нь маш бага. Энэ бүхэн эргээд бидэнд олонхүндэлгүүдийг авчирч байна. Буруу бодлого явуулсаас болсон хүндэрлэл маш их байгаа. Өнөөдөр 80 орчим мянган айлын орон сууц баригдаж байна. Түүнээс 20 орчим мянганг нь улсын комисс хүзээгээд авчихсан. Цаашлаад 25 мянга орчим айлын орон сууц улсын комисс хүзээгээж өгөхөд бэзэн бичихсон байна. Үлдсэн нь 70-80 хувьтай баригдчихсан орон сууц байх жишээтэй. Зогсчихсон. Ам.метрийн 1.5-1.6 саяар зарах гээд лүзээд байдаг. Зарагддагтүй. Иргэд авч чадахгүй байна. Нөгөө талаас гэр хорооллыг бид дахин төвлөж, газрыг нь чөлөөлж авья гэж байгаа. Өнгөрсөн дөрвөн жил гэр хорооллын газрыг чөлөөлөх гээд хэдэн компани үзсэн. Хэд хэдэн байрлал сонгож аваад л, газар чөлөөлөх гээд чамгүй л ажилласан. Үр дун маш бага гарлаа. Яагаад гэвэл, эдийн засгийн тооцоо судалгаа бага хийсэн. Эрэлт, нийтийн хоёрт хоёрт зөв тооцож чадалгүйгээр мөнгөө зарчихсан. Одоо яж засах вэ. Дахиад л хөрөнгө монгонийн асуудал яригдана. Энэ барилгуудыг чинь банкууд хөрөнгө гаргаад, айл бүрт орон сууц огно гэвэл тэд дараа нь монгое хаанаас олж авах билээ. Ингээд л төрийн оролцоо шаардлагатай болоод байгаа юм. Тийм болохоор бид дахиж нэг суугаад, маш зөв төлөвлөх хэрэгтэй байна. Засгийн газар олон яамдад хуваагдаж, нийслэл дотроо олон янз болж, тэр хэрээрээ баахан өөр өөр бодлого гаргахгүйгээр, нэг газарт зангидааг ажиллаамаар байна. Тулгамдаа байгаа олон асуудлаа нэгтгэж, нэг чигт ажиллаж байж бид үр дунд хүрнэ. Одоо бид их хэмжээний өр гадагш нь толөх гэж байна. ОУВС-ийн төлөөлгүйчид манайт ирчихсан байгаа. “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдах юмуу, яг ямар шийдвэр гаргах нь сонирхолтой байна. Гэх мэт маш олон асуудал байгаа, тэр болгоныг бид нэгдсэн нэг

бодлогоор шийддэг болохгүй бол цашид явахад хэцүү. Бодлогоо зангидах гаргамаар байна. Тэгснээр үр дун гарна. Манайх учиргүй дампуураад, хувхай хоосорчихсон улс биш шүү дээ. Монгол Улс бэзэн. Тэр дундаа нийслэл хот боломж ихтэй, ажиллах хүч ихтэй. Тэр болгоныг зөв хөдөлгөх ёстой. Тэгхийн тулд хөрөнгийг нь гаргаж, зөв зохицой, үр ашигтай зарцуулах л хэрэгтэй.

-Харин тэр хөрөнгө мөнгө хаанаас бидэнд олдох вэ гэдэг л байна?

-Засгийн газар ойрын хөршүүдээсээ хөрөнгө мөнгө босгот гээд л ажиллаж байна. Үүний бүгд л мэдэж байгаа шүү дээ. СаяХятаудалсаас эзэлтусламж авна, огно гээд хэлэлцээрүүд хийчихсэн байсан. Далай багшийн айлчлаас болоод хойшиллоо гээд л нийгэм даяар ярьсан. Энэ хэлэлцээрүүд цааш үргэлжлээд явж байгаа гэж бодож байна. Энэ бол Засгийн газрын хийх ажил. Мон мэдэж ОУВС монголчууд энэ хямралыг яаж даван туулах юм, боломж нь юу юм бэ гэдэг дээр зөвлөгөө, зөвлөмж өгөөд, ажиллаж байна. Дээрээс нь бид зөв бодлого гаргаж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах хэрэгтэй. Түрүүн би зангидаан нэг бодлого хэрэгтэй байна гэсэн дээ. Тухайлбал, энэ олон бэлэн орон сууциг хөдөлгөхийн тулд барилтын компанийдаа нэгтгээд, нэг том үл хөдлөх хөрөнгийн компани болгоод, зах зээл дээрээ үнэлээд, гадны хөрөнгө оруулалтын том байгууллагуудад зарах хэлбэр байж болно. Энэ олон барилтын компаниудыг нэг том корпораци болоод, орон сууциг үнэлгээг нь гаргаад, ногог талдаа төр батлан даагчаар оролцож болно шүү дээ. Энэ бол хөрөнгө оруулалт олох нэг л жишээ. Энэ мэтийн ажиллавал бидэнд боломж байна. Хөрөнгө байна шүү дээ. Тэр хөрөнгийг л ашиглах хэрэгтэй. Тухайлбал, нэг иргэн амины орон сууцаа банкинд барьцаанд тавиад, зээл аваад, ажлаа хийж болно. Тэгээд олсон ашиграа орох дарчихаж болдог биз дээ. Яг түүнтэй адил асуудлыг шийдэж болохор байгаа. Гагцхуу энэ бодлого нэг газар л зангидаага ёстой.

-Улаанбаатар хотод хүн

ороод амьдрахад бэлэн болчихсон 20 гаруй мянган айлын орон сууц байна гэсэн дээ. Удахгүй энэ тоо 40 мянгад хуржээр байна. Хэрвээ бэлэн орон сууцидаа айл орхөө оруулж чадвал 40 мянган яндан алга болох нь. Энэ асуудлыг л шийдэх хэрэгтэй юм биш үү. Дахиад төлөвлөгөөт гээд л байна. Дахиад нэмж барилга барих гэхээсээ илүү нэгэнт бэлэн болчихсон орон сууцидаа иргэээ оруулах ямар арга зам байна, тэрийг л хаймаар санагдах юм?

-Наадах чинь маш зөв асуудал.

Энэ асуудлад хариулахын тулд

дахиад л өнгөрсөн жилүүдээ

ярих шаардлагатай болно. Бид



Гэрэл зурагийн Г.АРГУУЖИН

онгөрсөн жилүүдэд 30, 40 мянган айлын орон сууц барьчихлаа. Энэ орон сууцыг төр баригчүү, хувийн хэвшлийнхэн зээлээ аваад, ачаагаа нуурун дээрээ үүрээд л босгосон. Засгийн буруу бодлогоос болж одоо эргээд эрсдэлээ өөрдөө үүрээд л яж байна. Өнгөрсөн жилүүдэд 40 гаруй мянган айлын орон сууц баригдсанараа тэр тооны яндан багассан уу гэвэл угүй. Харин ч эсрэгээрээ нэмэгдсэн. Ерөөсөө л бодлогын алдаа гарсан учраас үр дун гарсангүй. Харин бид одоо аль болох алдаатай бодлого гаргахгүй төлөө ажиллах хэрэгтэй байна. Эхнээсээ л зөв ажиллах хэрэгтэй. Ямар ч байсан бид яндан нэмэхгүй байх захирамж гаргачихлаа. Дээрээс нь нийслэлийн харьяан холбогдох байгууллага, хүмүүст үүрэг огч ажиллаж байна. Яндангуудаа бүртгэж эхэлсэн. Нэг хашаанд хэдэн яндан байна, бүртгэн. Харин дараа нь тухайн хашаанд яндан нэмэгдсэн байна уу гэдгийн хянана. Нэг өснөөдөр улаан шугам татсан газартай л яндан нэмүүлэхгүй байх арга хэмжээг авч байгаа юм. Өнгөрсөн жил гэхэд Улаанбаатарт 20-иод мянган яндан нэмэгдчихэж. Ердөө л жил хагасын дотор шүү дээ. Үүний л зогсох хэрэгтэй. Түүнийхээ дараа бид жил жилээрээ энэ яндангуудаа 10, 10 мянгаарны өөлөх бодлогобарина. Магадгүй 20, 20 мянгаар нь ч юм

уу. Ямар ч байсан эхний ээлжинд зогсоги байдалд орчихсон барилгын салбарыг хөдлөж, эргэлтэд оруулах хэрэгтэй. Тэгж байж жилдээ тодорхой тооны айл орх орон сууданд орно. Үүний тулд хөрөнгө мөнгөө босгено. Хөрөнгө босгено тулд ажиллах л хэрэгтэй. Ингээд шат дараалалтай арга хэмжээндээ аваад эхэлбэл. Цаашлаад хувийн хэвшилтэй хамтарч ажиллавал үр дун гарна. Би хувьдаа тэгж бодож байна. Ерөнхийдөө бид ажлаа эхлчихсан. Ур дун гарахад хугацаа хэрэгтэй, шат дараалалтай арга хэмжээ авна.

-Улаанбаатар хотын хаягжилтийн асуудлыг маш энгийн аргаар шийдэж байгаа гэсэн. Тэр талаараа яриач?

-Улаанбаатар хотод нэг тулгамдсан асуудал хаягжилт. Гэр хороолол тэлэхийн хэрээр хаягжилтийн асуудал улам бүр тулгамдах байна. Хаягжилт гэдэг бол эрүүл мэнд, цагдаа сэргийлэх, онцгой байдал, шудан холбоонд хүртэл маш чухал ач холбогдолтой зүйл шүү дээ. Бүр нарийн яривал пицца захиалахад хүртэл та тодорхой хаягтай байвал аятай юу даа, тийм биз дээ. Тиймээс бид Улаанбаатар хотын бурэн хаягжуулж, системтэй болгоё гэсэн зорилт тавиад ажиллаж байна. Үүний хүрээнд турван угийн холбоосор хаягжуулдаг Английн компанийн хийсэн ашиг Монголд нэвтрүүлж байгаа юм. Дэлхийн бомборцог тэр чигээрээ 57 их наяд есөн квадрат метрт хуваагдаж байгаа юм. Нэг квадрат нь хааш хааша турван метр гэсэн уг. Тэгвэл тэр квадрат болгон турван угээр нэрлэгдэнэ. Монгол, англиар турван уг нь гараад ирнэ. Тэгвэл Улаанбаатар хотын гэр хорооллыг турван угээр хаягжуулах ажил эхлээд яиж байна. Саяхан нийслэлийн Засаг даргын захирамж гарад, ажлын хэсэг хөр дахь хурлаа саяхан хийсэн. Хаягжилтийн асуудал шийдэгдсэнээр төрийн үйлчилгээ гэр хороололд очиждэг саадгүй болно. Та дудлаага оглю гэж бодьё. Дуудлага авсан газар google map дээр танай хаягны турван угийгутсан дээрээ хийгээд л яваад очно. Жилийн дараа гэхэд үр дун гарахад байх.

МЭДЭЭЛЭЛ



Гэрэл зурагийн Г.АРГУУЖИН

ГЭР ХОРООЛЫН ХҮҮХДҮҮДЭД НҮҮРЛЭСЭН АЮУЛ

Н.БАТЗАЯА

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Сургуулиас нийслэлийн таван цэгт амьдардаг хүүхдүүдийн цусан дахь хар тутгалгын агууламжийн шинжилгээ хийсэн байна. Тус эмнэлгийн хамт олон өнөөдөр хэвлэлийн бага курал хийд, шинжилгээнийхээ дүнг сэтгүүлчдэд танилцуулаа. Тэд нийслэлийн Баянхоншуу, Да хүрээ, Нарантуул, Хотын төв болон Зайсанд амьдардаг нийт 15 хүүхдэд шинжилгээ хийсэн ажээ. Хурлын үеэр АШПҮҮС-ийн Нийгмийн эрүүл мэндийн тэнхимийн сургуулийн Орчны эрүүл мэндийн хэмжээнээс хоёр

дахин их хэмжээтэй байна гэсэн уг. Гэхдээ 45 мкг/дл байвал аюултай хэмжээ гэж үздэг” гэв. Аюултай хэмжээнд хүрсэн тохиолдолд желatinийн эмчилгээ хийлгэх ёстой байдал аж. Мөн эмч, мэргэжилтүүд хүүхдүүдийн цусанд хар тутгалга ихсэх болсон шалтгаан нь юнаас ч хамааралтай байж болно. Хар тутгалга нь хоол, хүнс, амьдарч буй орчны бохирдол, уйндын усанд агуулагддаг. Мон агаарын бохирдолтой холбоогийн байх магадалтай гэдгийн онцолж байлаа. Энэ үеэр судлаач Э.Үндэрмар “Хар тутгалгы гэдэг нь неотоксик буюу мэдрэлийн үйл ажиллагаанд хортой нөлөө үзүүлдэг материал юм. Ялангуяа 0-5 настай хүүхдүүдийн мэдрэлийн үйл ажиллагаа эд эс хамгийн эрчимтэй хөгжжэй байдал. Энэ

үед хар тутгалгын дарсанд оношиорхуудийн тархи мэдрэлийн эд эс гэмтэх, зарим тохиолдолд мэдрэлийн эс дахин сэргэхгүйгээр үхсэнээр ой тогтоолт муудах гэм мэт шинж тэмдэг илэрч, үеийнхээ хүүхдүүдээс хөгжил дутуу байх хандлагатай байдал. Мэдрэлийн эс нь ахин толждоггүй учраас энэ хоногдолт насан түршдээ сэтгэн бодж чадварын хоногдолтой байдал. Түүчинэхэн хар тутгалга нь пусанд орсноор улаан эсийн тоо багасч, пус багадалт илэрдэг” гэсэн юм. Манай улсын хэмжээнд цусан дахь хар тутгалгын хэмжээг тогтоодог улсын гурав, хувийн нэг эмнэлгэг байдал.



СОНИРХУУЛАХАД



ДУУЧИН С.ТЭНГЭР САРААГИЙН “АРГАГҮЙ АМРАГ”-Т СЮРПРИЗ БАРИНА

Э.ТУУЛ

1⁶ наснаасаас поп урлагт зүтгэж, уран бүтээл туурвисныхаа 30 жилийн ойн тогтолцоороо фэнүүдийнхээ цангааг тайлсан поп хатагтай Б.Сарантуяа “Аргагүй амраг”-аарын дахин уулзахаар зээж байна. Хамгийн гол нь 20 жилийн омно Монголын рок поп урлагт тэсрэлт хийсэн “Аргагүй амраг” цомогт этник ардын дуундуудаас гадна поп хатагтай “Хайрын бурхан”, “Хэн юм б”, “Чи алзахгүй”, “Сэхүүн салхи” тэргүүтэй шилдэг хиттүүд нь багтсанаараа тухайн цаг үедээ ч хэн дуртай нь олж авч чадаагүй нандин эд байсан. Тиймдээ ч 20 жилийн дараа ийн хан дарсан хачин сайхан “жоо”-оо задалж байгаа сургаар нь Монголын рок попынхон, үзүүч фэнүүд нь ч Б.Сараад талархаж байгаа.

Хамгийн сонирхолтой нь “Аргагүй амраг” тоглолтод Фэрмонголын нэрт дуучин С.Тэнгэр урилгаар оролцож, “Зөвхөн Сараатай л дуулараа” гэж “Монгол тулгатны зуун эрхэм”-д ам гарснаараа “Зүүдний говь” дутг хамтран дуулахаар ирж байгаа юм байна. Товчондоо ар, өвөр Монголын алдартай хоёр дуучинг хамтад нь сонсох алтан боломж цор ганцхан удаа тохиох нь. Гол нь нэмж сануулахад поп хатагтайн 30 жилийн ойн тогтолтын тасалбар дерев хоногийн омно дусуч, чамгүй олон фэнүүд нь хаалганы ард үлдсэн. Энэ удаад ч “Аргагүй амраг” тогтолтын билет талаас илүү хувь нь захиалгад орж, эзэндээ очсон байгаа аж.

Тоглолт Монголын хамгийн ондor зэрэглэлийн Corgorate convention center концертэн танхимд энэ сарын 10-ны одор буюу маргааш 19:00 цагт “Аргагүй амраг” дахин тайзнаа ганцхан удаа амилах гэж байна. Энэ дашрамд нэг зүйлийн зориуд тодруулаад Corgorate convention center концертын танхим нь аль ч талаас нь узсэн урдаас нь харж үзэж буй мэт засалтай бөгөөд та бүхэн хайртай дуучныхаа тоглотыг сэргэл хангалиун үзэх боломжтой гэдгийг дуулгаа. Тасалбарын уз 50-70 мянган тогрог бөгөөд маш цөөхөн үлдсэн тул яараад.

ОДДЫН ЦАГ

“Улаанбаатарын өвлийн наадам” бямба гарагт нээлтээ хийнэ

3.МОНХСУВД

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Аялал жуулчлалын газраас “Улаанбаатарын өвлийн наадам-2017” гэр бүлийн баярыг энэ сарын 11, 12-ны одор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулах гэж байна. Өвлийн спортын төрлийн хослуулсан тус наадмын хүрээнд мөсөн шагайн харваа, мөсөн сурсын харваа, мөсөн хананы аширалт, уран гулгайлт, шүхрийн үзүүлбэр, мөсөн шатар, өвлүйн дугуй, дөрвөн дугуйт мотоциклийн парад зэрэг арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөжээ. Мөн хамгийн сайхан үндэсний хувцастай орлогчийн шалгаруулалтын зэрэгцээ гэр бүлийн хөгжөөнт болон цасан уралын тэмцээн явуулах аж. Түүчинэн аяллын хувцас, хэргэлэлийн үзэсгэлэн худалдаа ч гаргах юм байна.



Наадмыг үзэхээр ирсэн иргэд, жуулчид сур, шагай харваж, мөсөн хананд аширч, өвлийн дугуй, нохойтой чарга унаж нэг өдрийг зугтаагаа онгоорох боломжтой аж. Өвлийн наадмын тэмцээн уралдаанд оролцох сонирхолтой иргэд 70108687, 95193734, 98198687, 90218687 дугаарын утсаар холбогдж бүртгүүлэх аж. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх “Наадмын үйл ажиллагаа энэ амралтын өдрүүдэд болно. Бид энэ жилийн наадмыг “Гэр бүлийн баяр” нэртэйгээр зохион байгуулж байна. Тиймээс арга хэмжээ, хөтөлбөрүүд маань гэр бүл руу чиглэсэн байх болно. Бид олон сонирхолтой хөтөлбөр бүхий наадам зохион байгуулахаар төвлөвөсөн. Наадамд ирсэн иргэд, жуулчид эдгээрийг үзэж, харж, сонирхохос гадна тэмцээн уралдаанд оролцох боломжтойгоороо онцлогтой. Өвлийн наадам маань энэ бямба гарагийн 12:00 цагт албан ёсоор нээлтээ хийнэ” хэмээлээ.

Язгуур урлагийн гайхамшигийг сурталчилна

Монголязгуур урлагийн гайхамшигийг олон улсад сурталчлан таниулах зорилго бүхий “Эх ундарга” ардын урлагийн их наадам болох гэж байна. Энэхүү наадмыг Төрийн соёрхолт, МУГЖД Сосорбарамын санаачилгаар 2012 оноос хошиг Монгол түмний их баяр Цагаан сарын омно жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Наадамдарын урлагийг олон улсад сурталчилс бий “Хөсөгтон”, “Жонон”, “Их Монгол”, “Хэмнэл”, “Нүүдэлчид”, “Домог” зэрэг хамтлаг оролцно. Мөн 21 лимбэчин, товшуур бужигчин, уртын дууч, хөөмжийцээр

300 гаруй уран бүтээлч оролцо юм. Наадмын Ерөнхий найрууллагаар Монгол Улсын Төрийн соёрхолт, МУГЖД Сосорбарамын хөгжмийн зохиолчоор “Хөсөгтон” хамтлагийн ахлагч Д.Арчунболд нар ажиллас байна. Үндэсний язгуур урлагагаа гадаадад сурталчлах зорилгоо “Эх ундарга” наадмын видео бичигээг хилийн чанадад борлуулдаг байна. Тиймээс наадмыг үзэхээр зорьж буй иргэдийг үндэсний хувцасаар гоёхыг зохион байгуулагчдын зүгээс уриалав. Тоглолт энэ сарын 17-19-нд 19.00 цагт МҮЭСТО-нд болно.

ОДДЫН ЦАГ

63 настай супер модель сэтгүүлийн нүүрийг чимнэ

Б.ДАВАА



Энэ эмэгтэй харсан хэн ч 63 настай гэж итгэхгүй байх. Тийм ээ, тэр 63 настай. Наснаасаа бараг 20 гаруй наасаар зарлуу харгадаа супер модель Кристи Бринкли “Sports Illustrated” сэтгүүлийн тусгай дугаарын нүүрийг чимхээр болж. Ингэснээр тэрбээр энтертеймент өргөнцөд анх удаагаа ёдий насан дээрээ сэтгүүлийн нүүрт гарсан эмэгтэй болж байгаа юм. Тус сэтгүүл жил бүр тусгай дугаар гаргаж, нүүрийг нь залуу, үзэсгэлэнтэй загвар омсогчид чимсээр ирсэн байдал. 1979 онд Тайра Банкс чимж, анхны африк гаралтай загвар омсогч болж байсан бол Серена Уильямс нарын тамирчид ч сэтгүүлд гарч байв. Харин Кристи Бринкли 1975 оноос 2004 он хүртэл нийтдээ найман удаа тус сэтгүүлийн нүүрийг чимж байжээ. Тэгвэл тун саяхан 63 настны төрсөн одроо тэмдэглэсэн тэрбээр 18 болон 31 настай хоёр охиньхоо хамт энэ сарын 15-нд худалдаанд гарах сэтгүүлийн нүүрийг чимх нь ээ.

БИДЭНД ТОХИОЛДСОН



Нэг удаа ханиад хүрээд гэрээр тариа хийлгэхээр боллоо. Тэгсэн чинь тариа хийх хүн нь эзжээс өөр байдалт. За тэгээд эзжээрээ хэд хоног тариагаа хийлгэсэн чинь аймаар овтгөөд байхаар нь ингэж овдогд л юм байх гээд хийлгэж байгаад нэг огلوо эзжийн тариа найруулж байгааг харав аа. Тэгсэн суудлын тарианы шил чинь гадуураа цэнхэр хуванцар тагтай байдаг дaa. Тийшээ нь зүйтээ нэвт зоочихсон, найруулаад зогсож байдаг байгаа. За

тэгээд тийм юм руу зоосон зүү ямар байх нь ойлгомжтой. Тахийсан аймаар мурий зүүгээр тариад байсан байгаа юм чинь. Ёо би бур уйлах ч биш, инэхэд ч биш болсноо эзжээр дахиж тариулахгүй гээд нэг эгчийгээ гүйгаад гэрт нь очиж тариулав аа. Тэгсэн чинь учиргүй нус олгойдоод л явчихлаа. Ёо яичихав гэсэн чинь “Сүртэй ш дээ. Судас нь л таарчихлаа. Үхсэнээ хийж согтуу хүнээр тариуласан юм. Хохь нь” гэж авдаг юм. За тэгээд л ганц тариа хийлгэх гэж

юм юм болсны эцэст дараа өдөр нь найзаараа хийлгэв. Жигтэйхэн сайхан тарьчиллаа шүү. Тэгээд л оноохөө магтаад л ээж, эгчийн онгоог яриад л, инээдээд сүүж байсан чинь ширээн дээр нь нэг тариа байна. Юун тариа вэ гэсэн чинь “Өө яана аа тариаг нь найруулахаар маргчих” гээд тарианыхи усны дангаар нь шахчихсан байгаа юм даа. Ганц тариа тариулах гэж ингэж л хөглөж билээ. За тэгээд гэрээр тариа тариулах чинь алаан байхгүй юу...



ТЭНГИС

Happy Valentine Day



ХАЙРЫН ШУУДАН

ТЭНГИС
КИНО ТЕАТР

ХАЙРТАЙ ХҮНДЭЭ ХАМГИЙН САЙХАН СЭТГЭЛИЙН
ҮГЭЭ ИЛ ЗАХИДЛААР БИЧИЖ ТЭНГИС КИНО ТЕАТР ДОТОР
БАЙРШИХ ХАЙРЫН ШУУДАНД ХИЙНЭ ҮҮ

3 ХОС ШАЛГАРУУЛЖ 2-Р САРЫН 14-НД

- “FIFTY SHADES DARKER” УСК-ны хос урилга
 - “ДЭЛГЭЦЭЭР МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЭХ” эрхийн бичиг
 - “PREMIUM HOTEL” нэг оройг хамт өнгөрүүлэх эрхийн бичгээр тус тус шагнана.
- Захидалдаа холбоо барих утасны дугаараа үлдээнэ үү.

ХАЙРТАЙ ХҮНДЭЭ ХАМГИЙН ГОЁ СЮРПРИЗ БАРИХ БОЛОМЖ

2017.02.08-13 хүртэл
УТАС: 7000-8070

